

“ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ”

SOME CHALLENGING PROBLEMS OF CIVIL DECISION EXECUTION AND WAYS TO SOLVE IT



Э.Энхтуяа

*ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн
албаны сургуулийн магистрант, дэслэгч*

Товч утга: Шийдвэр гүйцэтгэгч нарын ажлын ачаалал, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тулгамдсан зарим асуудлыг тодотгон шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхийг эрмэлзлээ.

Abstract: Efforts have been made to highlight the workload of decision-makers and some of the problems of decision-making process, and seek ways to solve them. We strived to find a way to clearly solve it. We strived to find a way to clearly solve some of the problems of the decision makers' workload and decision-making process.

Түлхүүр үг: Шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, ажлын ачаалал,

Keywords: Decision maker, decision making process, workload,

ОРШИЛ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь тэртээ 13 дугаар зууны үеэс Чинсан алба буюу хааны зарлиг гүйцэтгэх албанаас эхлэлтэй бөгөөд орчин үеийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүх 1921 онд Гяндан салаа нэртэйгээр үүсч хөгжсөн гэж судлаачид үздэг билээ.

Шийдвэр гүйцэтгэх алба нь Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Агентлаг байгууллага тухай” 298 дугаар тогтоолоор Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар болгон өөрчлөн зохион байгуулсан түүхтэй. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн бүтцийн нэгжид болгон өөрчилсөн.

Харин 2002 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар Иргэний хэргийн, эрүүгийн хэргийн, захиргааны хэргийн, зөрчлийн хэргийн, арбитрын хэргийн, бусад хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг

Шүүхийн харьяанаас гаргаж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад нэгтгэн зохион байгуулснаас хойш 22 жилийн хугацаа өнгөрсөн байна.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, хорих ял эдлүүлэх ажиллагаанаас тэс өөр ойлголт бөгөөд шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдтэй эрх зүйн харилцаанд ордог онцлогтой билээ.

Гэтэл Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн төвийн 6 дүүрэг, алслагдсан 3 дүүрэгт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахаар алслагдсан 3 дүүрэг нь цагдан хорих байртайгаа хамт цагдан хорих байрны дарга нь тухайн дүүргийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс нэгжийн даргын албан тушаал эрхэлдэг бол аймгийн төвүүд дээр хорих анги, цагдан хорих байртайгаа шийдвэр гүйцэтгэх хэлтэс нь хамт шийдвэр гаргах эрх бүхий субъект нэгжийн дарга нь байх жишээтэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяанд Шийдвэр гүйцэтгэх алба, Хорих ял эдлүүлэх алба, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба ажиллаж байгаа ч хорих ял эдлүүлэх албаны дарга, тэргүүн дэд дарга байдаг зэргээс харахад улсын ерөнхий шийдвэр гүйцэтгэгчээс илүү эрх мэдэлтэй байна гэж судлаачийн хувьд үзэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд хариуцсан тойргийн шийдвэр гүйцэтгэгч, ахлах шийдвэр гүйцэтгэгч, улсын ерөнхий шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гаргах эрх бүхий субъект гэж зааж байдаг.

Бүтэц, орон тоо, удирдлагын хүрээнд цагдан хорих, хорих ял эдлүүлэх, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанаас иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүр мөсөн салгаж Улсын ерөнхий шийдвэр гүйцэтгэгч тэргүүтэй Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байгуулагдах хэрэгцээ шаардлага үүссэн гэж үзэж байна. Учир нь хорих ял эдэлж байгаа хоригдол, цагдан хоригдсон хоригдогч, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээгээр шийтгүүлсэн этгээдийн тоо, иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны төлбөр төлөгч, бусад этгээдээс харьцангуй бага тоотой байдаг нь судалгаагаар харагдаж байна.

Монгол Улсын хэмжээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан орон тоогоор нийт 244 шийдвэр гүйцэтгэгч, ШШГЕГ-ын даргын тушаалаар 47 ахлах шийдвэр гүйцэтгэгчтэй байхаар тус тус баталсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд батлагдсан орон тоогоор нийт 3400 гаруй албан хаагч байгаа бөгөөд одоо ажиллаж байгаа албан хаагчдын судалгаанаас үзвэл:

Хорих ял эдлүүлэх чиглэлээр 1986 буюу 65%,

Захиргааны чиглэлээр 479 буюу 16%,

Санхүүгийн чиглэлээр 300 буюу 10%,

Шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр 244 буюу 8% байна.

ШШГЕГ-ын даргын 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/104 дүгээр тушаалаар “ШШГБ-ын хэмжээнд ажлын байрны зураг авалт хийж, бүтэц орон тоо, албан тушаалын тодорхойлолт шинэчлэн Ажлын хэсэг” байгуулагдсан байна.

Түүнчлэн шийдвэр гүйцэтгэгч нарын ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан тоо судалгааг судалж үзэхэд 2018 онд 26 шийдвэр гүйцэтгэгч, 1 ахлах шийдвэр гүйцэтгэгч чөлөөлөгдсөн бол 2019 онд 10 шийдвэр гүйцэтгэгч өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн байна.

д/д	Он	Чөлөөлөгдсөн		Халагдсан		Нийт тоо	
		А/ш/г	ш/г	А/ш/г	ш/г	А/ш/г	ш/г
1	2016	-	-	-	1	-	1
2	2017	1	2	-	-	1	2
3	2018	1	26	2	1	3	27
4	2019	-	10	-	-	-	10
5	2020	-	2	-	1	-	3
6	2021	-	4	-	-	-	4
7	2022	2	10	-	-	2	10
8	2023	-	5	-	-	-	5

Дээрх судалгаанаас үзэхэд 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллыг хүчингүй болгосон, мөн төлбөр төлөгчийн хилийн хоригийг хуулиар хориглосонтой холбоотой гэж судлаачийн хувьд үзэж байна. 2024 оны 12 дугаар сарын байдлаар Монгол Улсын хэмжээнд 56909 гүйцэтгэх баримт бичгийн 3.4 их наяд төгрөгийг биелүүлэхээс 30301 гүйцэтгэх баримт бичгийн 1.1 их наяд төгрөгийг бодитой биелүүлж, улсын дундаж биелэлт 53,2 хувьтай, мөнгөн дүнгийн биелэлт 31,7 хувьтай байсан.

Тус газарт 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар иргэний шийдвэр гүйцэтгэгчээр ажиллаж байгаа 87 шийдвэр гүйцэтгэгчийн 66 буюу 75.86% нь эмэгтэй, 21 буюу 24.13%-ийг эрэгтэй албан хаагч эзэлж байна.

Мөн ажлын өрөөний зохион байгуулалтын хувьд мэдүүлэг, уулзалтын өрөө гэж байдаггүй. Нэг жижиг өрөөнд давчуу зайнд 4-5 шийдвэр гүйцэтгэгч багтаж ажиллах шаардлага үүсдэг. Шийдвэр гүйцэтгэгч эзэнгүй тойргийн ажлыг хүн томилогдох хүртэл давхар хариуцан ажилладаг.

Шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачааллын жишиг нормативд заасан нэг шийдвэр гүйцэтгэгчид 180 гүйцэтгэх хуудас гэсэн тоо хэрэгжих боломжгүй, гүйцэтгэх хуудас их ирдэг, хүйсийн тэнцвэртэй байдал алдагдсан, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхийг зорилоо.

ҮНДСЭН ХЭСЭГ

Нэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 288 дугаар зүйлийн 288.4-т “...Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг нормативыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална...” гэж заасан байдаг.

Монгол улсын хууль зүй дотоод хэргийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А247, А167, 303 дугаартай тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”-ийг шинэчлэн баталсан байдаг.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”-ийн 8 дугаар хуудсанд Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын иргэний хэргийн нэг шийдвэр гүйцэтгэгчид ногдох жишиг норматив 180 гүйцэтгэх хуудас гэж тодорхойлон заажээ.

Жишиг нормативыг баталсан боловч бодит байдал дээр ажлын ачаалал их байдаг. Улаанбаатар хотын дүүрэг бүрд, хүн амын нягтаршил, боловсролын байдал, захиргааны байгууллагуудын төвлөрөл, гэмт хэргийн гаралт зэргээс шалтгаалан өөрийн гэсэн тодорхой онцлог байдаг. Жишээ нь:

Чингэлтэй дүүрэгт гол төлөв Захиргааны байгууллагууд төвлөрсөн байдаг. Харин Сүхбаатар, Хан-Уул, Баянгол дүүрэгт өндөр үнийн дүнтэй анхаарал татсан гүйцэтгэх баримт бичгүүд их байдаг. Харин Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг нь хүн ам ихтэй, мөн гэмт хэргийн гаралт ихтэй, хүн амын нягтаршил тасралтгүй тэлж байгаа, захиргааны байгууллага, өндөр үнийн дүнтэй, бага үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичгүүд их байдаг. Тухайлбал;

Нэг дүүргийн нэг шийдвэр гүйцэтгэгчид 2023 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад эрэн сурвалжилж байгаа, хөрөнгө орлогогүй, хөрөнгийн үнэлгээний маргаантай холбоотой шүүгчийн захирамжаар түдгэлзүүлсэн, нэгтгэн явуулж байгаа зэрэг тодорхой шалтгааны улмаас шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн маш олон гүйцэтгэх баримт бичгүүд байдаг бөгөөд шуурхай мэдээнд бодогдож байгаа биелүүлбэл зохих гүйцэтгэх баримт бичгийн тоо 180-аас дээш, эсхүл доош байсан ч түдгэлзүүлсэн гүйцэтгэх баримт бичгийн тоог нэмбэл гүйцэтгэх хуудасны тоо 180-аас давчихдаг.

Энэ асуудлыг шийдвэрлэх нэг гарц нь шийдвэр гүйцэтгэгч нарт туслах ажилтны орон тоог хуульд тусгайлан зааж өгөх шаардлага үүссэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.9 дэх хэсэгт “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тодорхойлох, зарцуулах, төлбөр авагчид буцаан олгох журмыг хууль зүйн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж заасан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайд нарын 2018 оны 06 дугаар сарын

06-ны өдрийн А/107/132 дугаар “Журам батлах тухай” хамтарсан тушаалаар “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тодорхойлох, зарцуулах, төлбөр авагчид буцаан олгох журам”-ыг баталсан.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Журам батлах тухай” А/27 дугаар тушаалаар “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих журам”-ыг баталсан. Журмын 3.1-д “Энэ журмын 2.6-д заасан шаардлагатай зардлыг олгохдоо Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолоор баталсан албан хэрэгцээнд 50 км, дуудлагын автомашинд **40 км-ээс хэтрүүлэхгүй байх зардлын хэмжээнд нийцүүлж, тухай бүрд хуваарилна**” гэж, мөн журмын 3.6-д Гүйцэтгэх баримт бичигт заасан орон байр, барилга, агуулах савыг чөлөөлөх, барилга, байгууламжийг нураах, буулгах, хөрөнгө хадгалах, тээвэрлэх, шилжүүлэх, хөрөнгө худалдан борлуулах болон шинжээч оролцуулахад шаардлагатай зардлыг тухай бүрд тооцож, холбогдох зардлыг төлбөр авагчаас гаргуулна” гэж тус тус заажээ.

Энэхүү журмыг судалж үзэхэд дуудлагын автомашин ашиглах боломжтой байна гэж үзлээ.

Хоёр. Монгол Улсын үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т “...Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна...” гэж заасан.

Мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт зааснаар “...Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна...” гэжээ.

2012 онд батлагдсан одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр өөрчлөлт оруулж, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “...Энэ хуулийн 9 дүгээр зүйлд³⁹ заасан Хуульчийн мэргэжлийн дадлага гэдэгт дараах ажил, албан тушаал хамаарна...”, гэж заагаад шийдвэр гүйцэтгэгчээр ажилласан жилийг тооцохгүй байхаар хуульд өөрчлөлд оруулсан. Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2017 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хуульчийн мэргэжлийн дадлагад тооцох журам”-ын 2.1 дүгээр зүйлд

³⁹ Монгол улсын “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль”, УБ., 2012 он., 9 дүгээр зүйлийн 9.1-т “...Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуулийг төгсөж, хоёроос доошгүй жил мэргэжлийн дадлага хийсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хуульчийн шалгалтад орох эрхтэй..., мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “...Гадаад улсын хууль зүйн сургуулийг төгссөн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хуульчийн шалгалтад орох журмыг Хуульчдын холбоо батална...” гэж заажээ.

Хуульд заасан ажил, албан тушаал эрхэлснийг мэргэжлийн дадлагад тооцох гэж тодорхойлоод;

Мөн журмын 3.1-т “...Бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шийдвэр гүйцэтгэгч, өмгөөлөгч, нотариатч, арбитрч, тэдгээрийн туслах ажилтан, нарийн бичгийн дарга...” гэж тодорхойлсон боловч хуульд 2021 оны 1 дүгээр сард өөрчлөлт орж, шийдвэр гүйцэтгэгчээр ажилласан жил хуульчийн мэргэжлийн дадлага хийсэн хугацаанд тооцогдохгүй болсноос болоод зарим шийдвэр гүйцэтгэгч нар ажлаасаа гарч энгийн байгууллагад ажиллах болсон.

2022 оноос эхлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага төрийн цэргийн байгууллагын статустай болсон. Мөн шийдвэр гүйцэтгэгчээр ажилласан жилийг хуульчийн мэргэжлийн дадлага хийсэн хугацаанд оруулж тооцохтой холбоотой хэд хэдэн санал Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргэгдсэн гэх боловч Улсын Их Хурлын 2022, 2023 оны чуулганы хэлэлцэх асуудалд тусгагдаагүй, 2023 оны 6 дугаар сард болж өнгөрсөн, шийдвэр гүйцэтгэгч нарын нэгдсэн зөвлөгөөний үеэр яригдаж, санал авагдсан боловч хараахан бодит үр дүнд хүрээгүй байгааг анхаарах хэрэгтэй байна.

Гурав. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр Улаанбаатар хотын Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх зэрэг 6 дүүргийг хариуцсан 11 хэлтэс, хэлтсийн дарга буюу ахлах шийдвэр гүйцэтгэгч, нийт 91 шийдвэр гүйцэтгэгчийн орон тоотой боловч 2023 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 87 шийдвэр гүйцэтгэгч ажиллаж, хүн томилогдоогүй 4 сул тойрог байна.

Дөрөв. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хураагдсан хөрөнгийн үнэлгээ, шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан талуудаас болон гуравдагч этгээд буюу хөрөнгийн өмчлөгч, эзэмшигчээс шүүхэд гаргаж байгаа гомдлын тоо их байдаг. Үүнээс шалтгаалан шүүх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг болон хөрөнгийн үнэлгээг хүчингүй болгох нь цөөнгүй байдаг. Шүүхээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хянаж гомдлыг хянах хүртэл хүртэл гурван шатны шүүх хурлаар дамжин явсаар шүүхийн шийдвэр биелэгдэхгүй уддаг.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт талуудаас хөрөнгийн үнэлгээнд холбогдуулан гаргасан шүүхэд хянагдсан нэхэмжлэлийн тоо 2020 онд 111 байснаас нэхэмжлэлийг хангаж, үнэлгээг хүчингүй болгосон 21, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 85, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан 5 тохиолдол байна.

Харин 2021 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 216 байснаас нэхэмжлэлийг хангаж, үнэлгээг хүчингүй болгосон 26, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 181, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан 9 тохиолдол

байна. (Б.Даваасүрэн, 2021) Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын шүүх, олон улсын шүүх, арбитрын шийдвэр, захирамжид албадан гүйцэтгэх ажиллагаа явуулах явцад талуудаас хөрөнгийн үнэлгээ болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар гаргасан гомдлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.5-д заасны дагуу гүйцэтгэх хуудас олгосон шүүхэд гаргадаг.

Гүйцэтгэх хуудас олгосон шүүхийн шүүгч нь иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх гомдлыг хүлээн авч, иргэний хэрэг үүсгэхээсээ өмнө шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг буюу гүйцэтгэх баримт бичгийг татаж хянах тогтолцоо байхгүй, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр дагнасан шүүх Монгол улсад байхгүй байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх үндэслэлгүй гомдол гаргаж шүүхийн шийдвэр биелэгдэхгүй удааших нөхцөлийг бүрдүүлдэг.

Тав. Шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд төлбөрийн шаардлага нь өндөр үнийн дүнтэй буюу 50 сая ба түүнээс дээш үнийн дүнтэй байх нь түгээмэл байдаг. 2002 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд 2014 оны 12 дугаар сард нэмэлт орж мөн хуулийн 133 дугаар зүйлийн 133.4.4-т зааснаар төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж эхэлсэн байдаг.

Харин 2017 онд батлагдаж, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд 2020 оны 01 дүгээр сард нэмэлт орж мөн хуулийн 59 дүгээр зүйлд зааснаар 50 сая төгрөгөөс дээш хөрөнгийн шаардлага бүхий гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй эрэн сурвалжлагдаж байгаа, эсхүл төлбөр төлөхөөс санаатай зайлсхийсэн, хөрөнгөө нуун дарагдуулсан, төлбөр төлөхөөс зайлсхийх зорилгоор гадаад улсад оргон зайлж болзошгүй гэсэн үндэслэлээр гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэхээр хуульчилсан. Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж эхэлснээр төлбөр төлөгч төлбөрөө төлөх хөшүүрэг болсон. Тухайлбал:

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хэмжээнд 2020 онд 2732 гүйцэтгэх баримт бичигт холбогдох 2162 иргэн, хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлснээс шүүхийн шийдвэрт заасан төлбөрөө бүрэн төлсөн 52 гүйцэтгэх баримт бичгийн 61 төлбөр төлөгч иргэн хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн гадаадад зорчих эрхийг сэргээснээс 7 гүйцэтгэх баримт бичиг арбитрын шийдвэртэй, 9 төлбөр төлөгч иргэн-хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч байсан.

Мөн НШШГГ-ын 2021 оны 5 дугаар сарын байдлаар 510 этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлснээс 94 этгээд төлбөрөө төлж эрхээ сэргээлгэсэн байдаг.

Мөн гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах явцад төлбөр төлөгч, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчийн

гадаадад зорчих эрхийг төлбөрийн шаардлагыг биелүүлэх хүртэл хугацаанд түдгэлзүүлдэг боловч төлбөр төлөгч иргэн-хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчээс шүүхэд гомдол гаргах тохиолдол гардаг.

Шүүхийн шийдвэр болон шийдвэр гүйцэтгэгчийн заасан хугацаанд төлбөрөө хуваагаад төлөхгүй байгаа нь төлбөр төлөхөөс санаатай зайлсхийж байгаа үйлдэл гэж үзэхээр байхад шүүх нотлох баримт хангалтгүй, хуульд заасан үндэслэл бүрдээгүй, эсхүл мэдэгдэлгүй хилийн хориг тавьсан гэж үзээд гадаадад зорчих эрхийг сэргээх шийдвэр гаргах, үүнээс болоод Монгол Улсын хилээр гарснаас болоод шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удааширч улмаар төлбөр төлөгч, иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчийг Монгол улсын хилээр нэвтрэх хүртэл шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зогсоож түдгэлзүүлэхэд эрсдэл үүсч болно. Төлбөр төлөгч иргэн, этгээдийн төлбөрийн хэмжээг хэдэн төгрөг байснаас үл хамааран тодорхой төрлийн үүрэг хүлээлгэсэн, харилцан үүрэг хүлээсэн /Байр орон сууц, газар албадан чөлөөлөх, нураах гэх мэт./ мөнгө дүн шаардахгүй ч тодорхой зардалтай байдаг гүйцэтгэх баримт бичгүүдэд төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх хуулийн зохицуулалт үгүйлэгдэж байна.

Зургаа. Арбитрын тухай хуулийн 11 дүгээр зүйлд Арбитрын хэлэлцээр ба шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахаар шүүхээс авах арга хэмжээг зааж өгсөн бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт “...Шүүгч нэхэмжлэгчийн хүсэлтийг үндэслэн шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах дараах арга хэмжээг хэрэг үүсгэхдээ буюу үүсгэсний дараа захирамж гарган авах эрхтэй...” гэж заасан.

Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах үүднээс шүүгч, арбитрч нь хуульд заасны дагуу хөрөнгө хамгаалах, тодорхой үйлдэл хийхгүй байхыг даалгах, нотлох баримт хамгаалах буюу гаргуулах зэрэг тодорхой ажиллагаа явуулахыг даалгах, хариуцагчийн арилжааны банк дахь дансны зарлагын хөдөлгөөнийг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээнд зогсоох, эд хөрөнгө мөнгийг битүүмжлэхийг даалгаж захирамж гарган Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлдэг. Захирамжийг эх хувиар нь ирүүлж байгаагаас хугацаа алддаг тул цахим хэлбэрт шилжүүлж, жишээ нь баталгаат EDOC төрийн байгууллагын нэгдсэн цахим шуудангаар нэн даруй ирүүлэх, дараа нь эх хувийг ирүүлж байх хэрэгцээ шаардлага үүссэн гэж боддог.

Шүүх нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай салшгүй уялдаа холбоотой учраас иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгоход шийдвэр гаргасан шүүгч иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх гомдлыг хүлээн авахаасаа өмнө гүйцэтгэх баримт бичгийг татаж хянах, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих тогтолцоо байх нь чухал болоод байна.

ДҮГНЭЛТ

Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны нэг хэлбэр бөгөөд шүүхийн шийдвэр биелэгдэж шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болох хүртэл тасралтгүй үргэлжилдэг онцлогтой билээ.

Байгууллагын бүтэц, орон тоо, алба хаагчдын хүрээнд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр олон улсын туршлагаас үзвэл Шүүх эрх мэдлийн байгууллагын дэргэд ажилладаг байна, эсхүл эрх зүйн боловсрол хөгжсөн улсад хувийн хэвшлээр гүйцэтгүүлдэг сайн туршлага байна. Харин манай улсын хувьд гүйцэтгэх эрх мэдлийг байгууллагаас ангид буюу шүүхийн харьяанд бие даасан дагнасан шүүхтэйгээр тусдаа зохицуулсан эрх зүйн орчинг бий болгох шаардлагатай гэж судлаачийн хувьд үзэж байна.

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгоход тухайн шийдвэрийг гаргаж, албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудас олгосон шүүх хөрөнгийн үнэлгээг хүчингүй болгуулах болон иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх гомдлыг хүлээн авахаасаа өмнө гүйцэтгэх баримт бичгийг татаж хянах, шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай нягт уялдаа холбоотой ажиллах тогтолцоог бүрдүүлж, хүлээн авах ёстой гомдол мөн эсэхийг шалгаж, үндэслэлгүй нэхэмжлэл, гомдлыг хугацаа алдалгүй шалгаж, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалздаг болох шаардлагатай.

Мөн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх талаар мэдэгдлийг төлбөр төлөгч иргэн-хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчид биечлэн гардуулах гэж төлбөр төлөгчийг хайж, олох асуудлыг зогсоож, цахим шуудангаар эсхүл гар утсаар нь мэдэгдэж нэн даруй түдгэлзүүлж болох эрх зүйн орчныг бүрдүүлж, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг шүүх хүлээн аваад шүүх нотлох баримт хангалтгүй, хуульд заасан үндэслэл бүрдээгүй, эсхүл мэдэгдлийг биечлэн гардуулаагүй, оргон зайлах үндэслэл бүрдээгүй гэх үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгох явдлыг зогсоож, эвлэрлийг баталсан шийдвэрт заасан хугацаанд төлбөрийг хувааж төлөөгүй явдлыг төлбөр төлөхөөс санаатай зайлсхийж байгаа үйлдэлд тооцож төлбөр төлөгчийг оргон зайлахаас урьдчилан сэргийлэх хэрэгтэй юм.

Мөн шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг боловсронгуй болгож хөрөнгө хамгаалах захирамжийг цахим хэлбэрээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлэхээс гадна гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээг шаардлагатай тохиолдолд шийдвэр гарахаас өмнө хэрэгжүүлдэг болох эрх зүйн орчныг бүрдүүлж чадвал хариуцагч, төлбөр төлөгч нь гадаад улс руу оргон зайлахаас урьдчилан сэргийлэх боломж бүрдэх болно.

САНАЛ

1. Шүүх, шүүгч нар гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих
2. Шүүх хөрөнгийн үнэлгээг хүчингүй болгуулах болон иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх гомдлыг хүлээн авахаасаа өмнө гүйцэтгэх баримт бичгийг татаж хянах, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх,
3. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авахыг даалгасан шийдвэрийг цахим хэлбэрээр хүргүүлэх нөхцөлийг бүрдүүлэх,
4. Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх албадлагын арга хэмжээг шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээний нэг төрөл болгон авч үзэх, биечлэн мэдэгдэх шаардлагагүйгээр гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх
5. 2020 оны 1 дүгээр сараас хойш шийдвэр гүйцэтгэгчээр ажилласан жилийг хуульчийн мэргэжлийн дадлага хийсэн хугацаанд тооцдог болгох,
6. Шийдвэр гүйцэтгэгч нарын ажлын өрөө тасалгаа, ажлын байрыг өргөтгөж шинээр барилга байгууламж барих, талуудтай уулзалт хийх боломжтой уулзалтын өрөөнүүдийг бий болгох
7. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Банкны төлбөр барагдуулах газрыг татан буулгаж, дүүрэг тус бүр лүү шилжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.
8. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын бүтэц орон тоонд судлагдсан 60 тойрог дээр нэмж тойрог үүсгэх алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах, хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах бодлого баримтлах,
9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяанд байгаа Шийдвэр гүйцэтгэх албыг өргөтгөж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болгох
10. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түргэн шуурхай, үр дүнтэй явуулах зорилгоор Ubcab ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж туршилт хийх, дэвшилттэй үр дүн гарсан тохиолдолд практик ажиллагаанд нэвтрүүлэх.

НОМ ЗҮЙ

- **Хууль тогтоомж, дүрэм:**

1. Монгол Улсын Их Хурал. (2002). Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Улаанбаатар: Төрийн мэдээлэл эмхэтгэл, №08

2. Монгол Улсын Их Хурал. (2002). Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. Улаанбаатар: Төрийн мэдээлэл эмхэтгэл, №08
 3. Монгол Улсын Их Хурал. (2017). Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Улаанбаатар: Төрийн мэдээлэл эмхэтгэл, №24
 4. МОУҮА-ын Арбитрчдын зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 04 тоот тогтоолын хавсралт №1., Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм;
- **Судалгаа, хурлын эмхэтгэл;**
1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа Шийдвэр гүйцэтгэх албаны 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 03/2722 дугаар албан бичгээр өгсөн мэдэгдэл;
 2. Шийдвэр гүйцэтгэх алба. (2021). Иргэн захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн шинэтгэл сэдэвт хурлын илтгэлийн эмхэтгэл. Улаанбаатар;
 3. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Тоо бүртгэлийн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын судалгаа;
 4. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Тоо бүртгэлийн хэлтсийн 2021 оны 5 дугаар сарын судалгаа;

---o0o---